



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар A/315

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тэжээлийн ургамал хашаалах тор, шон нийлүүлэх ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Т.Сүхбаатар	(Хүнс, хөдөө аж ахуйн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Ч.Намуун-Эрдэнэ	(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж, ахуйн тасгийн дарга)
	Б.Нансалмаа	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)
	Ж.Бодьгэрэл	(“Үнэлэмж-Алтай” ХХК-ийн захирал (гүйцэтгэгч))
Нарийн бичгийн дарга:	Х.Нордогбат	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар тариалангийн үйлдвэрлэл, технологи, тасаг хариуцсан мэргэжилтэн)

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тэжээлийн ургамал хашаалах тор, шон нийлүүлэх ажлыг хүлээн авахдаа гэрээнд тусгагдсан ажлын даалгавар, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Т.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.

3.Хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г. ЧИНБАТ

